



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/85/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудиторын туслах: Ч.Даваасүрэн Утас: 99559722 Цахим хаяг: daavkach@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.4 Зөвлөмж	14
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 102

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үр дүнгийн урамшуулал илүү олгосон, амралт цалин давхардуулан олгосон, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалын (Хүүхдийн үдийн цай) зардлаас баримтгүйгээр зардал гаргасан, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалын (үдийн цай) зардлаас хангамжийн материал авсан, Төсвийн байгууллага төлбөрт сувгаар сургалт, сурталчилгаа явуулсан, татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй аудитлгах орлогоос суутгасан татварын авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлагыг санхүүгийн тайланд тайлагнаагүй, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зэрэг 45.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" журам, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020110

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,997,816.58	99,935,549.00
33	АВЛАГА	3,670,688.58	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,430,100.79	
335	Бусад авлага	240,587.79	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	240,587.79	
34	УРЬДЧИЛГАА	-	250,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	250,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	80,327,128.00	99,685,549.00
351	Түүхий эд материал	40,600.00	3,722,334.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,563,434.00
35130	Эм боох материал	40,600.00	1,158,900.00
354	Хангамжийн материал	80,286,528.00	95,963,215.00
35410	Бичиг хэргийн материал	277,300.00	63,000.00
35420	Аж ахуйн материал	388,500.00	287,200.00
35450	Барилгын засварын материал	588,750.00	166,000.00
35460	Хүнсний материал	9,000.00	323,940.00
35470	Бусад хангамжийн материал	79,022,978.00	95,123,075.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,239,598,463.51	6,064,013,424.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,239,598,463.51	6,064,013,424.44
392	Биет хөрөнгө	5,845,818,463.51	5,670,233,424.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,692,280,000.00	5,692,280,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(172,210,182.03)	(290,739,648.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,166,666.77)	(5,833,333.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	218,688,601.40	233,309,084.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,148,417.18)	(92,840,641.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207,198,213.60	212,380,902.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(60,321,770.31)	(98,799,029.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	680,000.00	9,241,818.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(181,315.20)	(765,725.86)
393	Биет бус хөрөнгө	393,780,000.00	393,780,000.00
39301	Програм хангамж	708,400.00	708,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(708,400.00)	(708,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	393,780,000.00	393,780,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	6,323,596,280.09	6,163,948,973.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	219,641.37	8,482,323.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	219,641.37	8,482,323.56
413	Өглөг	219,641.37	8,482,323.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	219,641.37	8,482,323.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,323,376,638.72	6,155,466,649.88
51	Засгийн газрын хувь оролцоо	6,323,376,638.72	6,155,466,649.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын санг орон	393,780,000.00	393,780,000.00
51101	Өмч: - төрийн	393,780,000.00	393,780,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,929,596,638.72	5,761,686,649.88
51210	Өмнөх үеийн үр дүн	5,929,596,638.72	5,929,596,638.72
51220	Тайлант үеийн үр дүн	-	(167,909,988.84)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,323,596,280.09	6,163,948,973.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,765,359,110.00	1,644,048,347.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,577,200.00	43,189,520.30
120	Нийтлэг татварын бус орлого	147,577,200.00	43,189,520.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	147,577,200.00	43,189,520.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	147,577,200.00	43,154,520.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,617,781,910.00	1,600,858,827.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,234,088,800.00	1,256,455,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,234,088,800.00	1,256,455,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,877,010.00	13,795,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө төсвийн саигууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,657,010.00	10,354,527.00
131105		1,220,000.00	3,441,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	349,816,100.00	330,607,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,816,100.00	330,607,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,795,778,655.27	1,811,958,336.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,795,778,655.27	1,811,958,336.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,684,658,776.06	1,759,470,477.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,039,754,750.00	1,052,121,646.28
210101	Үндсэн цалин	1,039,754,750.00	968,835,281.64
210104	Урамшуулал	-	83,286,364.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,395,193.21	136,699,573.56
210201	Тэтгэврийн даатгал	120,560,947.21	97,339,274.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,671,437.00	10,194,405.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,264,671.00	8,026,342.79
210204	Ажилгүйдлийн даатгал	445,285.00	1,918,667.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,452,853.00	19,220,882.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,337,295.51	327,596,728.00
210301	Гэрэл, цахилгаан	5,361,535.06	4,200,000.00
210302	Түлш, халаалт	283,787,248.45	315,196,728.00
210303	Цэвэр, бохир ус	8,188,512.00	8,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,376,895.00	16,056,960.00
210401	Бичиг хэрэг	1,935,200.00	2,097,060.00
210402	Тээвэр, шатахуун	5,560,000.00	1,997,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,500,000.00
210404	Ном, хэвлэл	-	3,494,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	860,000.00	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,540,830.00	5,798,500.00
210408	Бараа материал акталсны зардал	3,080,865.00	
2105	Нормативт зардал	253,400.00	4,527,491.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	253,400.00	1,744,671.00
210502	Хоол, хүнс	-	2,292,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,910,250.00	3,317,750.00
210604	Урсгал засвар	4,910,250.00	3,317,750.00
2107	Томиллолт, зочны зардал	600,000.00	-
210702	Дотоод албан томилолт	600,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,048,850.00	600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	30,000.00	600,000.00
210804	хураамж		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,850.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,982,142.34	218,550,328.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,301,350.00	7,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	7,600,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,160,792.34	203,950,028.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	111,119,879.22	52,487,858.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,401,734.00	42,842,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,806,214.00	37,451,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,657,010.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,938,510.00	5,391,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,478,804.49	10,572.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,478,804.49	10,572.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,239,340.73	9,634,546.93
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,239,340.73	9,634,546.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(30,419,545.27)	(167,909,988.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(30,419,545.27)	(167,909,988.84)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөгөө	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	393,780,000.00	0.00	5,960,016,184.00	0.00	6,353,796,184.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,780,000.00	0.00	5,960,016,184.00	0.00	6,353,796,184.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-30,419,545.27	0.00	-30,419,545.27
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,780,000.00	0.00	5,929,596,638.73	0.00	6,323,376,638.73
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	393,780,000.00	0.00	5,929,596,638.73	0.00	6,323,376,638.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,780,000.00	0.00	5,929,596,638.73	0.00	6,323,376,638.73
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	393,780,000.00	0.00	5,929,596,638.72	0.00	6,323,376,638.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	787,560,000.00	0.00	11,859,193,277.45	0.00	12,646,753,277.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл .Т
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,628,681,910.00	1,600,893,827.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,628,681,910.00	1,600,858,827.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,234,088,800.00	1,256,455,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,234,088,800.00	1,256,455,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,777,010.00	13,795,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,557,010.00	10,354,527.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд биелсэн нэмэлт орлого	1,220,000.00	3,441,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	349,816,100.00	330,607,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,816,100.00	330,607,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,617,989,760.00	1,596,364,827.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,617,989,760.00	1,596,364,827.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,507,191,544.78	1,541,915,808.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,042,620,569.27	1,045,944,212.49
210101	Үндсэн цалин	947,720,577.44	962,657,847.85
210104	Урамшуулал	94,899,991.83	83,286,364.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,263,800.00	131,193,636.58
210201	Тэтгэврийн даатгал	99,306,200.00	91,833,337.95
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,194,405.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,255,400.00	8,026,342.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,063,800.00	1,918,667.67
210205	Эрүүл мэндийн даатгал	20,638,400.00	19,220,882.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,337,295.51	327,596,728.00
210301	Гэрэл, цахилгаан	5,361,535.06	4,200,000.00
210302	Түлш, халаалт	283,787,248.45	315,196,728.00
210303	Цэвэр, бохир ус	8,188,512.00	8,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,409,680.00	15,087,300.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,439,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,560,000.00	1,997,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,500,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	3,494,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	860,000.00	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,889,680.00	5,486,100.00
2105	Нормативт зардал	1,852,500.00	3,317,971.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	852,500.00	1,992,371.00
210502	Хоол, хүнс	-	835,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,338,850.00	3,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,338,850.00	-
210604	Урсгал засвар	5,000,000.00	3,000,000.00
2107	Томилголт, зочны зардал	600,000.00	-
210702	Дотоод албан томилолт	600,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,048,850.00	600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,850.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,720,000.00	15,175,960.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,720,000.00	8,175,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,798,215.22	54,449,018.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,080,070.00	44,803,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,592,200.00	39,412,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,830,860.00	5,391,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,478,804.49	10,572.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,478,804.49	10,572.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,239,340.73	9,634,546.93
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,239,340.73	9,634,546.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,692,150.00	4,529,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,692,150.00	4,529,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,692,150.00	4,529,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,692,150.00	4,529,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,692,150.00	4,529,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,692,150.00)	(4,529,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,587,063,100.00	1,577,470,181.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,587,063,100.00	1,577,470,181.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,542,227,100.00	1,532,666,281.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,051,754,600.00	1,045,944,212.49
210101	Үндсэн цалин	979,891,200.00	962,657,847.85
210104	Урамшуулал	71,863,400.00	83,286,364.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,361,000.00	131,193,636.58
210201	Тэтгэврийн даатгал	92,950,000.00	91,833,337.95
210202	Тэтгэмжийн даатгал	10,067,000.00	10,194,405.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,569,000.00	8,026,342.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,071,000.00	1,918,667.67
210205	Эрүүл мэндийн даатгал	20,704,000.00	19,220,882.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,607,300.00	327,596,728.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,200,000.00
210302	Түлш, халаалт	315,207,300.00	315,196,728.00
210303	Цэвэр, бохир ус	8,200,000.00	8,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,908,200.00	12,638,400.00
210401	Бичиг хэрэг	1,439,800.00	1,439,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,997,000.00	1,997,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,500,000.00
210404	Ном, хэвлэл	111,700.00	70,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,500.00	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,461,200.00	6,461,200.00
2105	Нормативт зардал	2,105,000.00	2,104,571.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,615,000.00	1,614,571.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	490,000.00	490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	300,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	600,000.00	600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,591,000.00	9,588,733.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	7,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,591,000.00	2,588,733.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,836,000.00	44,803,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,836,000.00	44,803,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,436,000.00	39,412,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,400,000.00	5,391,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,587,063,100.00	1,577,470,181.07
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,256,455,800.00	1,246,838,453.07
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,256,455,800.00	1,246,838,453.07
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330,607,300.00	330,596,728.00
122005	Орон нутгийн төсвөөс	330,607,300.00	330,596,728.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,777,000.00	13,778,527.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,777,000.00	13,778,527.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,120,000.00	13,778,527.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,128,900.00
210404	Ном, хэвлэл	-	3,424,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	704,900.00
2105	Нормативт зардал	-	1,213,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	377,800.00
210502	Хоол, хүнс	-	835,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,900,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,220,000.00	8,436,227.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,220,000.00	8,436,227.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,657,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,657,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,657,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,777,000.00	13,795,727.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,777,000.00	13,795,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,557,000.00	10,354,527.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,220,000.00	3,441,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж хүргүүлээ.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын тухай хуульд заасны дагуу Есөнбулаг сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Суралцагч бүрийн сурлагын чанарыг ахиулна”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 1.765.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 35.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 28.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 1,644.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.3 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.5 хувиар буюу 159.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөг бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99.6 сая төгрөг болж 19.3 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 64.1 сая төгрөгийн, хандиваар үнэ төлбөргүйгээр 19.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 64.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 99.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,553.7 сая төгрөг болж 28.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4.6 сая төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 23.8 сая төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 8.5 сая төгрөг болж өссөн байна. Өглөг нь татвар нийгмийн даатгалын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,155.5 сая төгрөг болж 167.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 6.8хувиар буюу 121.3 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 5,929.6 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,318.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 731.7 сая төгрөгөөр бууруулж, 1,587.0 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал (1500 төгрөг) болж өссөнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,587.0 сая төгрөгийн төсөв баталснаас 1,256.4 сая төгрөгийг улсын төсвөөс 330.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,256.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 330.6 сая төгрөг нийт 1,587.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,577.4 сая төгрөгийг зарцуулж 9.6 сая төгрөгийг улсын төсөвт, 0.01 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,577.4 сая төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 5.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.01 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 0.3 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 10.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3.4 сая төгрөг нийт 13.7 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 8.4 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 4.1 сая төгрөг, нормативт зардалд 1.2 сая төгрөг зарцуулж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 2,857.2 сая төгрөгийн 155 мэдээллийг ил тод байршуулахаас 2,857.2 сая төгрөгийн 155 мэдээллийг ил тод байршуулсан, 305.9 сая төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мэдээлэл 89.3 хувь байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 5.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 24.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар:

- Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгийн үнэ, шинж чанарт дүн шинжилгээ хийх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй

Дараагийн аудитаар:

Татварын үлдэгдлийн тооцоог хянаж баталгаажуулах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 42.4 сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

- ✓ Үр дүнгийн урамшуулал 0.2 сая төгрөг илүү олгосон нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- ✓ Амралт цалин давхардуулан 2.4 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлын 2021/06/02-ны өдрийн "Ээлжийн амралтын хуваарь батлах тухай Б/46 тоот тушаал" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- ✓ Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалын (Хүүхдийн үдийн цай) зардлаас баримтгүйгээр 0.6 сая төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах"; заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- ✓ Шинээр томилогдсон болон ажиллаж байсан багш нарын цалингийн шатлал зөрүүтэй тогтоосоноос цалин 0.1 сая төгрөг илүү, 1.9 сая төгрөг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." , Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлын 2021/01/04-ны өдрийн Бүтэц орон тоо батлах тухай А/01 тоот тушаал” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ

- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалын (үдийн цай) зардлаас 0.1 сая төгрөгийн хангамжийн материал авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Төсвийн байгууллага төлбөрт сувгаар 0.4 сая төгрөгийн сургалт, сурталчилгаа явуулсан нь Төсвийн тухай хууль 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/-ыг, 41.2.2-д /батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах/” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд 8.5 сая төгрөгийн өглөг, 0.3 сая төгрөгийн авлага шинээр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй аудитлгах орлогоос суутгасан татварын 30.9 сая төгрөгийн авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 0.2 сая төгрөгийн авлага санхүүгийн тайлангаас зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	9	45.6			3	3.2	6	42.4		